БАТЛАВ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.САРАНЦЭЦЭГ

БАТЛАВ
БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.АЛТАНГЭРЭЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГАА ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 02 дугаар сарын 03 өдө Дугаар.01 Жаргалант сум

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Газрын тухай хуулийн 58 дугаар зүйл; - Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”; - Барилга, хот байгуулалтын Сайдын 2019 оны 34 дүгээр тушаалаар батлсан “Хот, суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”.
2.	Ажлын зорилго	Газрын тухай хуульд заасны дагуу Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт хот, тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлыг гүйцэтгэх, мониторингийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэх, мэдээллийн санг баяжуулахад энэхүү ажлын зорилго оршино.
3.	Хамрах хүрээ	Жаргалант сумын төвийн тэг гортигийн хот, тосгон, бусад суурины 713.6 га газарт мониторингийн сүлжээний 16 цэгийг хамруулан гүйцэтгэнэ.
4.	Ажлын иж бүрдэл	1. Хянан баталгааны ажлын тайлан (цаасан, тоон хэлбэрээр) боловсруулж, тайланг тоон хэлбэрээр дараах байдлаар захиалагчид хүлээлгэн өгнө. Үүнд: - Үндсэн тайлан (jargalant_tailan.doc болон jargalant _tailan. pdf); - Нэгдсэн хүснэгт (jargalant _husnegt.xls); - Хянан баталгааны нэгж талбарын дүгнэлт (B6440000467.doc болон B6440000467.pdf); - Мониторингийн цэгийн хувийн хэрэг (M6440000467.doc болон M6440000467.pdf). 2. Хавсралт материалыг мониторингийн цэгийн дугаараар нэг хавтаст хийж, тоон хэлбэрээр дараах байдлаар захиалагчид хүлээлгэн өгнө. Үүнд: - Хээрийн судалгааны фото зураг (Heer_photo.jpg); - Сканердсан ургамлын бичиглэл (urgam_bichiglel.pdf); - Сканердсан хөрсний бичиглэл (hurs_bichiglel.pdf); - Лабораторийн шинжилгээний дүн (dun_shinjilgee.pdf); - Боловсруулалт хийсэн агаар, сансрын зураг (jargalant _satellitename.tiff); - ArcGIS ажлын файл (jargalant _mxd.mxd); - Тоон мэдээллийн нэгдсэн сан (jargalant _gdb.gdb). 3. Хот тосгон бусад суурины газрын мониторингийн мэдээлэлийн санг доорх давхрагтай үүсгэнэ. -Үндсэн болон дэд нэгж талбар Мониторингийн цэг Газрын газаргын эвдрэл, бохирдлын талбай.

		Хөрсний дээж Ургамалын бичиглэл Хэрэв ундны усны дээж авах тохиолдолд. 4. Газрын мониторингийн цахим системд дараах мэдээллийг оруулна. Үүнд: - Хот, тосгон, бусад суурины газрын мониторингийн цэгийн хөрс, ургамлын судалгааны мэдээлэл, хянан баталгааны дүгнэлт, сүлжээний зураг (тоон хэлбэрээр); - Мониторингийн цэгийн мэдээлэл, цэгийн хувийн хэрэг.
5.	Гүйцэтгэх ажлын үе шат, хэмжээ	**1. Бэлтгэл ажлын үе шат** - Хянан баталгаа хийх газрын газарзүйн нөхцөл, газрын нөөцийн судалгаа, мэдээллийг цуглуулж нэгтгэн дүгнэх, зураглах; - Газрын кадастрын мэдээллийн санд үндэслэн хянан баталгаа хийх газрын зориулалт, байршил, хэмжээ, газрын эрхийн талаар судлах; - Өмнө нь хийгдсэн хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлт болон шаардлагатай бусад материалыг холбогдох газраас хуулбарлан авч харьцуулан дүн шинжилгээ хийх, тоон хэлбэрт хөрвүүлэх; - Өмнө нь хийгдсэн хянан баталгааны ажлын хүрээнд тодорхойлсон мониторингийн цэгийн байршил, шинээр байгуулах шаардлагатай мониторингийн цэгүүдийг судлан төлөвлөх, газрын кадастрын зураг, суурь зургуудтай давхцуулж, ажлын зураг зохиох, хянан баталгааны ажиглалтын талбарыг нарийвчлан тодорхойлж ажлын зурагт тусгах; - Хээрийн судалгаанд ашиглах өндөр нарийвчлал бүхий хиймэл дагуулын болон дроны загвар хүчин чадлын мэдээллийг захиалагчид хүргүүлэх; - Хээрийн судалгааны замын маршрут гаргах; - Хээрийн судалгаанд шаардлагатай багаж хэрэгсэл, программ хангамжийг бэлтгэх. **2. Хээрийн судалгааны үе шат** - Одоо байгаа мониторингийн цэг болон шинээр байгуулж буй мониторингийн цэг тус бүрээс хөрсний дээж авч, хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэх, ургамлын бичиглэл хийх; - Ажиглалтын талбарт буй гадаргын ус, худаг, уст цэгээс усны дээж авч, лабораторид шинжилгээ хийлгэх; - Хөрсний зулгаралт, элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлтийн байдлыг тодорхойлон ажлын зурагтай тулган нарийвчлах; - Өндөр нарийвчлал бүхий агаар, сансрын зураг, дроны зургаас газрын гадаргын механик өөрчлөлт, элэгдэл, эвдрэл, хөрс-ургамлан нөмрөгийн төлөв байдлыг тодруулан, ажлын зурагтай давхцуулан өөрчлөлтийн хил заагийг тогтоох. Үүнд: 1. Хөрсний зулгаралт, элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлтийн байдлыг тодорхойлон ажлын зурагтай тулган нарийвчлах; 2. Ажиглалтын талбарт байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас элэгдэж эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээг тодорхойлох; 3. Ажиглалтын талбарт буй хог ургамлын тархалтын хил заагийг тодорхойлох; 4. Хог хаягдлын цэг, хог хаягдлаар бохирдсон газрын байршлыг 2 долгионы GPS болон гар GPS ашиглан тогтоож, хамрах хүрээг зураглах;

		5. Газар ашиглалтын аюулгүй байдал, байгаль орчинд сөрөг нөлөөлөх үзүүлэлтийг судлан тогтоох. **3. Материал боловсруулалтын үе шат** - Хөрсний лабораторийн задлан шинжилгээний хариуг үндэслэн дүн шинжилгээ хийх, үр дүнг нэгтгэх; - Хөрсний лабораторийн задлан шинжилгээний дүнгээр бохирдол илэрсэн цэгүүдийн бохирдлын хил заагийг тогтоон зураглах, бохирдуулагч эх үүсвэрийг тодорхойлох; - Хөрсний механик бүрэлдэхүүн, карбонат, чулуужилт, элсэн хуримтлал, ялзмагт давхаргын нимгэрэлтийг тодорхойлох; - Хянан баталгааны үзүүлэлт бүрийг өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулах, хээрийн судалгаагаар тодорхойлсон элэгдэл, эвдрэл, доройтолд өртсөн газруудын талбайн хэмжээг нэгтгэн дүгнэх, зурагт оруулах; - Элэгдэж эвдэрсэн газар, бохирдсон газрыг нарийвчлан тогтоож зурагт оруулах; - Газар хамгаалах, нөхөн сэргээлт хийх шаардлагатай байршлуудыг тогтоон зураглах; - Судалгаагаар тодорхойлогдсон газрын төлөв байдал, чанар, нөлөөллийн бүх үзүүлэлтийг кодлон, ажлын зурагтай холбон, мэдээллийн сан үүсгэж, хянан баталгааны дэлгэрэнгүй хүснэгтийг боловсруулах; - Хянан баталгааны тайлан, ажиглалтын талбар бүрийн дүгнэлтийг эцэслэн боловсруулах; - Мониторингийн цэгийн хувийн хэрэг хөтлөх. **4. Ажлыг хянуулах, хүлээлгэн өгөх** - Хянан баталгааны ажлын тайланг захиалагч байгууллагаар хянуулах, захиалагчаас ирүүлсэн шаардагдах засваруудыг гүйцэтгэх; - Ажлын эцсийн үр дүнг Газрын мониторингийн цахим системд оруулах; - Ажлын эцсийн үр дүнг Жаргалант сумын Засаг даргын тамгын газар, Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тайлагнаж, хүлээлгэн өгөх.
6.	Техникийн шаардлага	- Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоо”; - Барилга, хот байгуулалтын Сайдын 2019 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Хот, тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”; - ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/306 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээллийн сангийн загвар батлах тухай”; - Байгаль хамгаалал, хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 3298-90; - Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019; - Газар зүйн мэдээллийн системийн ArcGIS программ хангамжийг ашиглан тоон зургийг боловсруулах; - Сүүлийн 12 сарын хугацаанд авсан 15 хүртэлх метрийн орон зайн шийдэлтэй сансрын зураг ашиглах; - Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (Дрон)-ийн зураг ашиглах; - Зайнаас тандан судлалын арга зүй ашиглах, тухайн мэргэжлийн боловсон хүчинтэй байх;

		- Ажлын тайланг Arial, 12 фонтоор, мөр хоорондын зай 1.15, хуудасны дээд захаас 20 мм-ээс доошгүй, доод захаас 20 мм-ээс доошгүй, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм байхаар боловсруулна.
7.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс эхэлж 6 сарын хугацаанд дуусна.
8.	Ажлын хяналт шалгалт	- Захиалагчийн хяналтын зардлыг нийт үнийн дүнгийн 3 (гурван) хувиар тооцно. - Захиалагчийн хяналтыг Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтэн гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд ГЗБГЗЗЕГ-ын Газрын мониторингийн хэлтсийн холбогдох албан хаагчийг байлцуулж болно. - Захиалагч ажлын 3 үе шатанд хяналт тавих бөгөөд хээрийн ажлын хяналтыг тус хээрийн ажил гүйцэтгэх явцад хийнэ. - Гүйцэтгэгч гэрээнд тусгасан хугацаанд 3 үе шатны тайланг ирүүлнэ. - Захиалагч ажил шалгасан акт гаргаж, хяналтын ажлыг баталгаажуулна.
9.	Салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгөх материал	- Бэлтгэл ажлын үе шатны тайлан, цаасан хэлбэрээр- 1 хувь, тоон хэлбэр /DVD/-ээр - тус бүр 3 хувь; - Хээрийн ажлын үе шатны тайлан, цаасан хэлбэрээр- 1 хувь, тоон хэлбэр /DVD/-ээр - тус бүр 3 хувь; - Эцсийн үе шатны тайлан, цаасан хэлбэрээр- 1 хувь, тоон хэлбэр /DVD/-ээр - тус бүр 3 хувь; - Агаар, сансрын зураг – 3 хувь /DVD/.
10.	Захиалагч байгууллага	Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар
11.	Гүйцэтгэгч байгууллага	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны болон газар зохион байгуулалтын төлөвлөлт чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ.
12.	Санхүүжилт, эх үүсвэр	Орон нутгийн төсөв, 20,000,000 /Хорин сая/ төгрөг
13.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

oOo

ХЯНАСАН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ДОЛЖИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ЗУУРЬ, СУДАЛГАА, ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.НАРМАНДАХ

БАТЛАВ.
ГАЗАР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
А.ЭНХМАНЛАЙ
2026 оны 01 дугаар сарын 09 -ны өдөр

БАТЛАВ.
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.САРАНЦЭЦЭГ
2026 оны 01 дугаар сарын 15 -ны өдөр

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ТОДРУУЛАЛТ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 01 дугаар сарын 09 Дугаар 2026/А5/08 Улаанбаатар хот

д/д	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	• Монгол Улсын Үндсэн хууль • Геодези, зураг зүйн тухай хууль • Газрын тухай хууль • Соёлын өвийг хамгаалах тухай хууль • Монгол хэлний тухай хууль • Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлиг • Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоол • Монгол Улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө • Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол • ГЗБГЗЗЕГ-ын даргын баталсан Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд хийх ажлын ТЭЗҮ (2023 он)
2.	Ажлын зорилго	Баянхонгор аймгийн Жаргалант сумын газар зүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх
3.	Хамрах хүрээ	Баянхонгор аймгийн Жаргалант сумын нийт нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэр *(УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэр болон бусад газар зүйн нэр)*
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл.
5.	Ажлын иж бүрдэл	1. Газар зүйн нэрийн суурин судалгаа хийх: • Улсын Их Хурлаар батлагдсан нэрийн судалгаа хийх; • ГЗБГЗЗЕГ-аас газар зүйн нэрийн тодруулалт хийсэн 1:100000-ны масштабтай байр зүйн зураг авч Улсын Их Хурлаар батлагдсан нэртэй харьцуулах; • Улсын Их Хурлаар батлагдаагүй газар зүйн нэрийн судалгааг гаргах; • Байр зүйн зурагт байршлаараа буруу тэмдэглэгдсэн газар зүйн нэрийн судалгаа гаргах; • 1:25000-1:100000-ны масштабтай байр зүйн зураг, хаягийн зураг дээрх газар зүйн нэрийг Улсын Их Хурлаар батлагдсан нэртэй харьцуулах;

		• Шинээр буй болсон газар зүйн объектууд (*Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 11.3 дахь хэсгийг үндэслэнэ)*, тэдгээрийн нэрийн судалгаа хийх. 2. Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх: • Улсын Их Хурлаар батлагдсан нэрийн тодруулалтыг хийх; • Шинээр буй болсон болон устаж үгүй болсон газар зүйн объектууд, тэдгээрийн оноосон нэрийг тодруулах, тогтоох; • Газар зүйн нэрийг солбицолжуулах. 3. Шинээр буй болсон объектын газар зүйн оноосон нэрийн санал боловсруулах; 4. Газар зүйн нэр бүрт хувийн хэрэг үүсгэх; 5. Улсын Их Хурлаар батлагдсанаас бусад нэр бүрт (уламжлалт нэр, шинэ нэр) хүсэлтийн маягт бүрдүүлэх; 6. Газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх; 7. Газар зүйн нэрийн жагсаалт гаргах; 8. Сумын газар зүйн нэрийн зураг зохиох (1:25000-1:200000-ны масштабтай), Зураг зүйн зөвлөх инженерээр хянуулсан байх; 9. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар (сумын газар зүйн нэрийн салбар зөвлөл) газар зүйн нэрийн жагсаалтыг, шинэ болон өөрчлөгдсөн нэрийг хэлэлцүүлэх; 10. Тайлан бичих, хүлээлгэн өгөх.
6.	Техникийн шаардлага	1. Геодезийн солбицол, өндрийн тогтолцоо, тусгаг: • Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолын дагуу геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд гүйцэтгэх. 2. Нэрийн тодруулалт, солбицолжуулалт, хувийн хэрэг, шинэ нэр өгөх болон нэр өөрчлөх санал: • Газар нутгийн нэрийн альбом ашиглах; • Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толийг ашиглах; • Улсын Их Хурлаар батлагдсан нэрийг өөрчлөхгүй байх; • 1:25000-1:100000-ны масштабтай байр зүйн зураг, мэдээллийн санг ашиглах. 3. ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/333 дугаар тушаалаар баталсан “Газар зүйн нэрийг тогтоох, тодотгох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох дүрэм”-ийг баримтлах. 4. Газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх: • ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны А/202 дугаар тушаалаар баталсан “Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн загвар”-ыг баримтлах. 5. Ашиглах багаж хэрэгсэл, программ хангамж: <u>Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмж:</u> • Жижиг оврын гар GPS; • Зураг авах камер; • Компьютер; • Автомашин. <u>Боловсруулалтын программ, хангамж:</u> • Газар зүйн мэдээллийн сангийн программ хангамж.
7.	Ажлын хяналт, шалгалт	Ажлын гүйцэтгэлд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал хяналт тавина. Ажлын гүйцэтгэлийг шалгаж хүлээн авахад төсөвт өртгийн

		дүнгээс 4 хувиар тооцож ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулах хяналт шалгалтын ажилд зарцуулна.
8.	Ажлын үр дүнг хүлээлгэн өгөх	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/161 тоот тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн төрийн архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, баримт хүлээн авах журам"-ын дагуу доорх баримт бичиг, тоон мэдээллийг хүлээлгэн өгнө. Үүнд: - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт: 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан (тоон болон хэвлэмэл байдлаар) - 2%; 2. Газар зүйн нэрийн зураг (хэвлэмэл байдлаар)-1%; 3. Хувийн хэрэг, хүсэлтийн маягт, газар зүйн нэрийн зураг, мэдээллийн санг цахим байдлаар (*gdb, *doc, *pdf, *jpeg (газар зүйн нэрийн зураг зохиож бэлтгэсэн эх файл layout)(өргөтгөлтэй), тухайн газар зүйн нэртэй холбоотой түүх, хүний ярьсан дуу бичлэг, фото зургийг (CD,DVD) дээр бичих - 2%; - Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт: 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан (тоон болон хэвлэмэл байдлаар) - 1%; 2. Газар зүйн нэрийн зураг (хэвлэмэл байдлаар)– 1%; 3. Хувийн хэрэг, хүсэлтийн маягт, газар зүйн нэрийн зураг, мэдээллийн санг цахим байдлаар (*gdb*doc, *pdf, *jpeg өргөтгөлтэй), (CD,DVD) дээр бичих - 2%; - Жаргалант сумын Засаг даргын тамгын газарт: 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан (тоон болон хэвлэмэл байдлаар)- 1%; 2. Газар зүйн нэрийн зураг (хэвлэмэл байдлаар)– 1%; 3. Хувийн хэрэг, хүсэлтийн маягт, газар зүйн нэрийн зураг, мэдээллийн санг цахим байдлаар (*gdb*doc, *pdf, *jpeg өргөтгөлтэй), (CD,DVD) дээр бичих - 2%;
9.	Захиалагч байгууллага	Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар
10.	Гүйцэтгэгч байгууллага	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ. Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагатай хуулийн этгээд байна.
11.	Санхүүжилт, эх үүсвэр	Баянхонгор аймгийн Жаргалант сумын орон нутгийн төсөв – 19,900,000 төгрөг (Арван есөн сая есөн зуун мянга)
12.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Ажлын даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ХЯНАСАН:
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАЛ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.МӨНХЦЭЦЭГ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Б.АМАРЗАЯА

ЗӨВШӨӨРСӨН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА — Б.ӨНӨРБАЯР

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — Д.АЛТАНГЭРЭЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА — А.ЦЭЦЭНБИЛЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Ц.ОРЛОГО

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Б.ЭНХЧИМЭГ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН, ЖАРГАЛАНТ СУМЫН ГАЗРЫН ДААМЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Б.ОТГОНЧИМЭГ